

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ
ХИЙХ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД УРЬЖ БАЙНА.

Улсын бүртгэлийн ерөнхий газраас Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2019 оны А/909 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Улсын бүртгэлийн байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал”-ын дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2023 оны үйл ажиллагаанд Хэрэглэгчийн үнэлгээ хийлгэх хөндлөнгийн үнэлгээний байгууллагыг нээлттэй сонгон шалгаруулалтад оролцохыг урьж байна.

Нэг. Үндсэн зорилго

Төрийн байгууллагаас хэрэгжүүлж байгаа бодлого, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн болон иргэдэд хүргэдэг үйлчилгээ чанартай, хүртээмжтэй, хүнд сурталгүй шуурхай байгаа эсэх талаар иргэдийн хандлагыг тандан судалж, түүнд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр цаашид хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагааг тодорхойлоход оршино. Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтыг баримтлан ажиллана. Үүнд:

- 1.Бүртгэлийн үйлчилгээ болон бодлого, үйл ажиллагаа иргэдэд хүрсэн байдлыг үнэлэх;
- 2.Цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар иргэдийн саналыг авах, судлах;
- 3.Иргэдээс авсан санал асуулгын дүнд үндэслэн үзүүлэх үйлчилгээг сайжруулах, цаашид авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх;

Хоёр. Хэрэглэгчийн үнэлгээний хамрах хүрээ, түүврийн хэмжээ

А.Үнэлгээний хамрах хүрээ

- а) Төрийн захиргааны байгууллага, албан тушаалтанд өгч буй иргэдийн үнэлэмжийг судлах;
- б) Улсын бүртгэлийн ерөнхий газраас иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад үзүүлж байгаа үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар буюу хэрэглэгчийн сэтгэл ханамжийн байдалд үнэлгээ хийх;

Б.Түүврийн хэмжээ

Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 15-ны “Удирдамж, үзүүлэлт батлах тухай” 302 дугаар тушаалын 2 дугаар хавсралтад “тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн насанд хүрсэн иргэдийн 5 хүртэлх хувийг хамруулна” гэж заасны дагуу статистикийн хувьд хүчинтэй түүврийн хэмжээнд хамруулна.

Гурав. Үнэлгээ хийх байгууллагад тавигдах шаардлага

А. Хэрэглэгчийн үнэлгээ хийх хөндлөнгийн үнэлгээний байгууллага дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Судалгаа, шинжилгээ, үнэлгээний чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх
2. Санхүүгийн болон хүний нөөцийн чадавхтай, үйл ажиллагаа нь тогтмолжсон байх. /Багийн ахлагч эсвэл аль нэг гишүүн нь эрх зүй, төрийн удирдлагын чиглэлээр магистр ба түүнээс дээш зэрэгтэй, судалгааны чиглэлээр мэргэшсэн байх/;
3. Үнэлгээг удирдамжид заасан хугацаанд хийж гүйцэтгэх чадвартай байх;
4. Байгууллага иргэдээс авах санал асуулгаа Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 302 дугаар тушаалын Удирдамжийн хавсралт-2 /Иргэдээс сэтгэл ханамжийн судалгаа авах санал асуулгын хуудасны ерөнхий загвар/ дагуу бэлтгэх;
5. Аливаа улс төрийн нам, хүчний хараат бус байх, үзэл бодлоос ангид байх;

Б.Хөндлөнгийн үнэлгээний байгууллага сонгон шалгаруулалтад оролцохдоо техникийн болон санхүүгийн саналаа ирүүлэх бөгөөд үүнд дараах мэдээлэл орсон байна.

1. Үнэлгээ хийх сонирхлоо илэрхийлсэн албан бичиг;
2. Техникийн санал;
 - Түүврийг сонгох, мэдээлэл цуглуулах арга зүй;
 - Хэрэглэгчийн үнэлгээг гүйцэтгэх ажлын төлөвлөгөө;
 - Багийн бүтэц, бүрэлдэхүүн, туршлага, товч намтар;
3. Санхүүгийн санал;
4. Байгууллагын танилцуулга;
 - Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ;
 - гүйцэтгэсэн ижил төстэй төслийн туршлага танилцуулга;
 - байгууллагын менежментийн чадавх нөөц;

V. Үнэлгээ хийх байгууллага дараах үүрэгтэй байна. Үүнд:

1. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 302 дугаар “Удирдамж, үзүүлэлт батлах тухай” тушаалын 2 дугаар хавсралтыг удирдлага болгон, санал асуулгын үнэлгээний аргачлал, үнэлгээ хийх ажлыг зохион байгуулж, хэрэгжүүлж ажиллана.
2. Улсын бүртгэлийн ерөнхий газартай байгуулсан гэрээ болон УБЕГ-ын даргын баталсан ажлын удирдамжийг биелүүлж ажиллана.
3. Байгууллагын нууцлалыг чандлан хадгална.

Дөрөв. Хэрэглэгчийн үнэлгээнд тавигдах шаардлага, тайлагналт

Хэрэглэгчийн үнэлгээг тавигдах шаардлагын түвшинд нэгтгэн гүйцэтгэж, ЗГХЭГ-ын даргын 302 дугаар тушаалын хүснэгт-3 /Тайлагналт ба хугацаа/, удирдамжийн хавсралт-3 /Тайлангийн бүтэц/ дагуу гаргаж, дүнг Улсын бүртгэлийн ерөнхий газрын Даргын зөвлөлийн хуралдаанд танилцуулна.

Тав. Сонгон шалгаруулалтын материал авах хугацаа, байршил

Сонгон шалгаруулалтын материалыг 2023 оны 09 дүгээр сарын 08-ны өдрөөс 2023 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийг дуустал 08 цаг 30 минутаас 12 цаг 30 минут, 13 цаг 30 минутаас 17 цаг 30 минут хүртэл доорх хаягаар хүлээн авна.

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 11 дүгээр хороо,

Улсын бүртгэлийн ерөнхий газар, Утас: 7000-7593, 7011-8183

Цахим хаяг: enkhnanan@burtgel.gov.mn